



**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ САЙД**

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160

Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,

Цахим шуудан: info@mddc.gov.mn,

Цахим хуудас: www.mddc.gov.mn

2024.06.27 № 01/1355
танай _____-ны № _____-т

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Б.БААСАНДОРЖ ТАНАА

Хэрэгжилт хүргүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-д заасны дагуу тус яаманд хамаарах “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2024 оны 2 дугаар улирлын хэрэгжилтийн тайланг үүгээр хүргүүлж байна.

Тайланд холбогдох нотлох баримтуудыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем www.unelgee.gov.mn -д оруулан баталгаажуулсан болно.

Хавсралт 22 хуудастай.



Н.УЧРАЛ

1524066571

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр
Цахим хөгжил, харилцаа холбооны яам
2024 оны эхний хагас жил



Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2024 оны зорилгот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь	
ГУРАВ, ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО								
1	3.4.6. Баян-Өлгий, Увс, Ховд, Баянхонгор, Архангай, Ойрот-Тува, Дорнод, Завхан аймгуудад аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлж, өтгөлх цэг, авто зам дагуу үйлчилгээний цогцолборудыг байгуулах, Говийн бүсийн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	4. Монголын говьд шинжлэх ухаан, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг MARS-V /Survival хэрэгжүүлнэ. /Survival буюу даван туулж, тэсэж гарах чадвар олгох мэргэжлийнхэн болон сонирхогчдад зориулсан MARS-V академи байгуулах	2020 - 2024	-	Тонот төхөөрөмжүүдийг суурилуулан, байгууламжуудыг нэмж, сонирхогчийн баазын хүчин чадлыг нэмэгдүүлнэ.	МУ-ын Ерөнхий сайдын АНУ хийсэн айлчлалын үеэр 2023.08.03-нд Марс-Ви төслийн Технологи хөгжүүлэлтийн багийн ахлагч НАСА-ын удирдлагуудтай хийсэн уулзалтад төслийг танилцуулсан. Марс-Ви төслийн гишүүд Марсын Арт "Be Ready" уран бүтээлийн үзэсгэлэн 2023 оны 05 дугаар сард гаргасан. Марс-Ви төслийн Марсын технологи хөгжүүлэлтийн парад зориулж, Сонгинохайрхан дүүрэгт 8623.1ткв газрыг 60 жил эзэмших эрхтэйгээр авсан. МУ-ын Ерөнхий сайдын 2022 оны 119 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан МУ-ын Шадар сайдаар ахиулсан ажлын хэсгийн 3 дахь удаагийн хурлыг 2023.10.13-ны өдөр зохион байгуулав. Хамтын ажиллагааны санамж бичгийг Марсын нийтэмлэгтэй 2023 оны 04 сард, АНУ-ын Конрадогийн их сургуультай 09 сард байгуулав. Марс-Ви төслийн "Сансрын хоол" хөгжүүлэлтийн баг 09 сард байгуулагдаж, ТЭСО гүйцэтгэж хамтарч Альфа хөтөлбөрт түшиглэх хоол хүнс бэлэн бүтээгдэхүүнийг хийв. "Дэлхийн Сансрын 7 хоног Монголд" үйл ажиллагааг 2023.10.04-10-ны өдөр хамтран зохион байгуулж, "Space networking event"-г зохион байгуулсан. АНУ-ын Аризоныгийн Их сургуульд 2023 оны 10 сард Марс нийтэмлэгийн 26 дахь удаагийн чуулганд Марс-Ви төслийг танилцуулав. Япон Улсын Токио хотноо 2023.11.07-09-нд Олон Улсын Марс Судлалын ажлын хэсгийн хуралд төслийн үйл ажиллагааг танилцуулсан. "Марсын Хүн од эрхсийн дуулал" номын нээлтийг 2023.11.17-нд хийв. Марс нийтэмлэгтэй хамтран 2023.11.26-12.09-нд АНУ-ын Юта мужид байрлах Марсын Цөлийн Судалгааны төвд Альфа хөтөлбөрийн хүрээнд 14 хоног даалгавар гүйцэтгэв. Альфа хөтөлбөрийн тайланг 2024.01.12-ны өдөр 13 дэмжилч, хамтрагч байгууллагын 40 гаруй оролцогчийг хамруулан зохион байгуулсан. МУ-ын Ерөнхийлөгчийн ивээл дор Сансрын түршлтийн 2 бөмбөлөг 2024.03.22-ны өдөр Үндэсний цацарлалт хүрээлэнгээс хөөрөгж, 2024.03.23-нд "Олон Улсын Сансрын Бөмбөлгийн чуулга уулзалт"-ыг зохион байгуулсан. "Марс хол биш 2" баримтат нэвтрүүлгийг 2024.04.12-ны өдөр олон нийтэд түгээсэн. MARS-V SPOT танилцуулгыг Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгийн 3541 ажилтан, албан хаагчдад хийв.	Хавсралт нийт : 25 Файл : 10 Зураг : 15	50%
ДӨРӨВ, ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
2	1. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ.	1. Төрийн байгууллага хоорондын мэдээллийн урсгалыг цахимжуулж, албан хэрэг хөтлөх, албан бичиг солилцоог цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, албан бичиг солилцооны цахим систем хөгжүүлнэ.	2021 - 2022	-	-	2023 онд Албан бичиг солилцооны дундын Досх системд 1,530 байгууллага холбогдсон бөгөөд 2024 оны 06 дугаар сарын байдлаар 321 байгууллага шинээр холбогдож нийт 1,851 байгууллага албан бичгийг цахим хэлбэрээр солилцож байна.	100%	

3	2. Хиймэл оюун ухаанд суурилсан технологийг ашиглан иргэдэд төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдэл хүргэх нэгдсэн платформ хөгжүүлж нэвтрүүлнэ.	2020 - 2024	-	Хиймэл оюун ухаан ашиглан, иргэдэд шаардлагатай мэдээллийг урьдчилан мэдэгдэх боломж бүрдэнэ	1 "Е-Mongolia 4.0" хувилбарыг 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдөр амжилттай нээсэн. Шинэчлэлийн хүрээнд зээл авах, виз мэдүүлэх, бичиг баримт захиалахад шаардлагатай лавлагаа тодорхойлолтыг иргэдийн хэрэгцээнд тулгуурлан баталсан үйлчилгээнүүд хэлбэрээр хиймэл оюун ухааны тусламжтайгаар санал болгодог болов. Мөн дуу хоолой ашиглан авах үйлчилгээг хайх боломжийг хиймэл оюунд тулгуурлан бий болгосноор хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлж байна. Замын хураамж, тээврийн болон жолоочийн торгууль, үер ус, угаарын хийн мэдрэгчийн мэдээллийг ухаалаг мэдэгдэл хүргэх системийн тусламжтай хүргэдэг болно. Эрүүл мэндийн 7 үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. 2. Иргэдэд төрийн байгууллагаас олгодог баримт бичиг, гэрчилгээ, зөвшөөрөглтэй холбоотой төрөл бүрийн мэдээлэл, мэдэгдлийг Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia.mn)-ээр дамжуулан авах боломжийг бүрдүүлж, иргэдэд 2024 оны 06 дугаар сарын сүүлийн байдлаар нийт 29,105,777 мэдэгдлийг хүргэсэн. Үүнээс үндэсний цахим шуудан (68% буюу 19,803,235), хувийн цахим шуудангийн хаяг (1.4% буюу 442,286), Push Notification (30.6% буюу 8,908,164)-ээр дамжуулан хүргэсэн. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэнийг холбоосон мэдээлэл дамжуулах цахим сувгаг болох Үндэсний цахим шуудангийн систем (www.mn.e-mongolia.mn)-ийг нэвтрүүлж, 1,846,867 хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. 3. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д гадаадын иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулах, төрийн үйлчилгээг авах боломжийг бүрдүүлсэн. 4. Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia)-д эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд яаралтай тусламжийн үйлчилгээг авах, цахим орчинд хүүхэд өөрийгөө хамгаалах, урьдчилан сэргийлэх талаар мэдээ, мэдээлэлтэй танилцах боломжийг бүрдүүлж, "E-kids" шийдлийг нэвтрүүлж, Танилт нэвтрэлтийн Дан системээр 25,265 орчим хүүхэд бүртгүүлж, 41,406 хүүхэд нэвтэрч ашигласан байна. Хавсралт : 1 Файл	100%
4	4.1.3. Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ.	3 Төрийн цахим үйлчилгээний e-Mongolia платформын ашиглалтыг нэмэгдүүлэх, иргэдэд танин мэдүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2020 - 2024	-	Цахим үйлчилгээний нэгдсэн платформоор дамжуулан үйлчилгээ авч буй иргэдийн тоог 200 000-р нэмэгдүүлсэн байна.	100%

5	4. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчилнэ	2022 - 2023	-		Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсвийг 2023 оны төсөвт тусуулахаар Сангийн яам болон Монгол Улсын Их хуралд 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 албан бичгээр хүргүүлсэн боловч Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд тусгагдлаагүй. Иймээс Монгол Улсын суурь гэрчилгээжүүлэх байгууллагын өнөөгийн нөхцөл байдлад тулгуурлан Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх системийг шинэчлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцооллыг гаргаж, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад "Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх" төслийн хэрэгжүүлэхээр тогтоон, Уг төслийн хүрээнд "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх" төслийн ажлын үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны ажил гүйцэтгэлийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны ажил гүйцэтгэлийг баримт бичгийг боловсруулж, олон улсын тендер зарлах зөвшөөрөл авахаар Дэлхийн Банканд хүргүүлсэн.	Хавсралт : 3 файл	50%
6	5. Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулна	2022 - 2024	-	Олон улсын жагсаалтад орсон байна	Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацитай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Үндэсний нийтийн түлхүүрийн хэрэглээнд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх" төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн. Ажлын даалгавраар шинээр байгуулагдах суурь систем, цагийн бүртгэлийн системд аудит хийх байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавигдах шаардлагыг тусгасан. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх төслийн ажлын даалгаварт Дэлхийн Банкаас ирүүлсэн саналыг тухай бүр тусгасан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх" төслийн ажил гүйцэтгэлийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсөл бүрэн хэрэгжиж дууссаны дараа олон улсын байгууллагаар аудит хийлгэх ажлыг гүйцэтгэнэ.	Хавсралт : 2 файл	50%
7	4.1.4. Төрийн үйлчилгээнд харилцаа холбооны технологийн дэмжихэд дэвшил, инновац нэвтрүүлэх замаар бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ.	2021	200.0	-	Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн 21 сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг "Шил ажиллагаа"-ны "shilen.gov.mn" системд ил тод байршуулсан. Үүнээс Цахим хөгжил, харилцаа холбооны яамны эрхлэх асуудлын хүрээнд өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан болон Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхлэх асуудлын хүрээнд архивын согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангууд үйл ажиллагаа эхлээгүй тул санхүүгийн зарцуулалтгүй, Батлан хамгаалах яамны эрхлэх асуудлын хүрээнд зэвсэгт хүчний хөгжлийн сан төрийн болон албаны нууцад хамаарадаг тул системд байршуулах боломжгүй байна. Тус албан даалгаврын биелэлтийг "Хангалттай" гэж үзэн Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн хуралдаанд танилцуулсан. Shilen.gov.mn цахим системийн 2.0 хувилбарыг ашиглалтад нэвтрүүлэх, шил ажиллагааны хэрэгжилтийг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Улсын Их Хуралд "Шил" ажиллагааны хэрэгжилтийг танилцуулахтай холбогдуулан мэдээллийг Ерөнхий сайдын Ажлын албанд 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 01/858 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын бүх тусгай сангийн мэдээллийг ил тод байршуулан цаашид шинэчлэлийг хийлгэхээр холбогдох байгууллагын албан хаагч нэгт системийн админ эрхийг олгож, сүргэлтэд хамруулсан.	www.shilen.gov.mn	100%

8	1. Сум, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно	2021 - 2022	-	-	Монгол Улсын хэмжээнд Хөвсгөл аймгийн Ханх, Дорнод аймгийн Дашбалбар, Төв аймгийн Мөнгөморьт, Баян-Өнжүүл, Баянжаргалан сум шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдсоны байдла бүгд Найрамдах Хятад Ард Улсын хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэх "Харилцаа холбооны салбарын хүртээмж, чанар, хангалтыг сайжруулах төсөл" -ийн хүрээнд дээрх 5 сум болон Увс аймгийн Тэс сумын Тэс боомт, Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Зэлээр боомт, Дорнод аймгийн Баян-Уул сумын Ульхан боомтыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор төслийн баримт бичиг боловсруулсан бөгөөд Түстайлсан зээлийн хэлэлцээрийг өндөр дээд түвшний айлчлалын үеэр байгуулахаар ажиглаж байна. Хавсралт : 3 файл	100%
9	2. Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна.	2021 - 2024	5,077.4	-	Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах мэдээллийн зангилаа төвийг Дархан-Уул аймагт байгуулахаар 2022 онд тус аймагт 2000 мива талбай бүхий 2 давахар төвийг байгуулах ажлыг эхлүүлсэн бөгөөд газар шороо, суурийн цутгалт хийгдсэн, 2023 онд карказ, өрлөг, шавар, газардуулга, гадна шугам сулжээ, дээвэр, шат доовж, агаар сэлгэлт, гадна авто замын цутгалт, цонхны ажил хийгдэж дууссан. Одоогоор бодит гүйцэтгэл 80 хувьтай, Дотор заслын ажил, дотор цахилгааны ажил, гадна заслын ажил, дотор холбооны ажил болон дулаан дамжуулах төвийн барилгын ажил хийгдэж байна. Төслийн гүйцэтгэгч компанийтай байгуулсан гэрээний хугацааг 2024 оны 03 дугаар сарын 15-ны өдөр сунгасан. Хавсралт : 14 файл	70%
10	3. Үндэсний дата төвийн техник, хүчин чадалыг сайжруулна.	2021 - 2022	7,300.0	Үндэсний дата төвийн техник, хүчин чадал, багтаамжийг нэмэгдүүлнэ.	Үндэсний дата төв УТҮГ-ын 2023 оны хөрөнгө оруулалтаар нийт 18 хадгалах төхөөрөмж бүхий 20 сервер, тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулж, клауд дэд бүтцийг өргөтгөсөн. Үүлэн дэд бүтцийн 10 серверийн шуурхай санах ойт 5 терабайт хэмжээгээр нэмэгдүүлсэн. Үндэсний дата төвийн үйл ажиллагаанд "тсCloud" (https://tscloud.gov.mn) системийг нэвтрүүлж, 2024 оны 2 дугаар улирлын байдлаар тсCloud системд 23 байгуулалын 127 хийсвэр сервер үүсгэсэн байна Хавсралт : 2 файл	90%
11	4. Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлнэ.	2022 - 2023	-	Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлэх таатай нөхцлийг бүрдүүлсэн байна.	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийг 2023 онд нэвтрүүлэхтэй холбогдуулан үг технологийн онцлог өндөр хурдны хөдөлгөөнт холбоо, машин хоорондын холбоо, юмсын интернетийн үйлчилгээний талаарх 8 салбарын зах зээлийн судалгааг хийж, Хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлэхэд шаардлагатай радио давтамжийн нөөцийг бүрдүүлэх ажлын хүрээнд анхны туршилтыг 2021 оны 09 дүгээр сарын 17-19-ний өдөр ХХМНТ-аас зохион байгуулсан "Digital Nation" арга хэмжээний үеэр амжилттай зохион байгуулсан ба туршилтад БНХАУ-ын Зэт Ти И компанийн хөгжүүлсэн харилцаа холбоо, дэд бүтэц, автоматжуулалт, IoT-д тулгуурласан 8 бүтээгдэхүүнийг, үүрэн холбооны Мобиком корпораци ХХК, Юнтел ХХК-ийн 5G технологид тулгуурласан IoT бүтээгдэхүүнээ тус тус олон нийтэд танилцуулсан болон интернэтийн үйлчилгээний Ондоо брэнд бүтээгдэхүүнээ тус тус олон нийтэд танилцуулсан 2022 онд Улаанбаатар хотын Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт Мобиком корпораци ХХК, Юнтел ХХК, Ай Эн Мобайл ХХК, Скайтел ХХК-иуд хөдөлгөөнт холбооны 5 дахь үеийн (5G) системийн туршилтын бүсийг үүсгэж, туршилтыг амжилттай хэрэгжүүлсэн. 5G технологийг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангахын тулд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/42 дугаар тушаалаар Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгтийг баталсан. Харилцаа холбооны зохицуулах хорооноос "Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлага"-ыг 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 106 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан. Тус хорооны даргын 2023 оны 10 дугаар сарын 02-ны өдрийн А/279 дүгээр тушаалаар Дараа үеийн хөдөлгөөнт холбооны системд ашиглах радио давтамжийн зурваст тусгай зөвшөөрөл олгох, сонгон шалгаруулалтын баримт бичиг бэлтгэх ажлын хэсэг байгуулагдсан. Үг баримт бичиг бэлэн болоход сонгон шалгаруулалт зарлагдаж, 5G технологид ашиглах радио давтамжийн зурвасын олголт хийгдэнэ. Хавсралт : 3 файл	90%

12	5. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.	2021 - 2023	-	Монгол Улсын хөрөнгө оруулалтын 2021-2025 оны хөтөлбөрийн төсөв шаардлагатай төслийн жагсаалтад оруулсан. Сангийн наманд 2023 онд хэрэгжүүлэх төсөл болон төсвийн тооцооллыг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 01/956 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-т заасны дагуу Улсын хэмжээнд нэгдсэн нөхцөл байдлын дүн шинжилгээ хийх ажлын хүрээнд өргөн нэвтрүүлгийн аналог дэд бүтцийг тоон технологид шилжүүлэх нэн шаардлагатай байгааг тодорхойлж, холбогдох мэдээллийг боловсруулан 2017, 2019 онд Сангийн наманд удаа дараа хүргүүлсэн ба тухайн онд хэрэгжүүлэх төсөв болон төслийн тооцооллын жагсаалтад багтаагүй. Цахим хөгжил, харилцаа холбооны сайрын багцын 2023 оны төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.3-т заасны дагуу Сангийн яам болон Улсын Их Хуралд хүргүүлсэн. 2021-2023 оны төсөвт уг төслийн санхүүжилт багтаагдаагүй тул хэрэгжүүлэх боломжгүй байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны А/76 дугаар тушаалаар байгуулсан ажлын хэсэг “Хонхорын аналог Радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх” техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулсан. Хавсралт : 4 файл	30%
13	7. Худал сувагчлалын багтаамжийг оновчтой ашиглах үүднээс том оврын физик болон ашиглахгүй байгаа шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулна	2021 - 2023	623 км физик кабель чөлөөлж, 80 км шилэн кабель татсан байна.	2023 онд харилцаа холбооны худал сувагчлалд ашиглалтгүй болсон 100 хосоос дээш физик болон шилэн кабелийг /хуучны/ сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах ажлыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Монголын цахилгаан холбоо ХК хамтран хэрэгжүүлж байна. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь КШ-32 чиглэлд 7592.5м, КШ-34 чиглэлд 2374.5м, КШ-351 чиглэлд 4635.3м, КШ-36 чиглэлд 13924.7, КШ-45 чиглэлд 10133.6м, КШ-63 чиглэлд 1045.6м, КШ-68 чиглэлд 3525.4м, нийт 43231.6 м кабель чөлөөлсөн. 2024 онд Сонгинохайрхан дүүргийн 12, 13, 14, 15, 17 дугаар хорооны кабель шугам 68 хэсэгт 5,703 метр /5,7 км/ ашиглахгүй байгаа хуучин шилэн кабелийг сувагчлалаас чөлөөлж, шинээр их багтаамжийн шилэн кабелийг суурилуулах, шилэн кабелийн сүлжээний багтаамжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 48,934.6м кабель чөлөөлж, шилэн кабель татсан. Хавсралт нийт : 16 файл : 2 Зурга : 14	40%
14	4.1.5. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ.	2021 - 2024	-	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мэдээлэл холбооны операторуудын ассоциацийн багтай хамтран “Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зурга төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм”-ийг шинээр боловсруулсан. Газрын тухай хууль болон Орон сууцны тухай хуульд өөрчлөлт оруулах саналыг боловсруулж Барилга, хот байгуулалтын яаманд 2022 оны 08 дугаар сарын 05-ны өдрийн 01/1319 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Газрын тухай багц хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн. Барилга, хот байгуулалтын яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн хурлаар “Барилгын мэдээлэл холбооны болон менежментийн системийн сүлжээний зурга төслийн төлөвлөлтийн норм ба дүрэм”-ийг хэлэлцүүлж, дэмжигдэв. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иас 07 дугаар сарын 07-ны өдөр Худал сувагчлал, кабель шугамын байгууламжийг хамгаалах, шилжүүлэх, шинээр суурилуулах техникийн нөхцөлийг баталсан. Хот төлөвлөлтийн судалгааны институтээс 09 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан уулзалтад Барилгын хөгжлийн төвд “Сэлбэ сэргэлт” төслийн Багц-1 болон Багц-2 хэсэгт таарсан холбооны худал сувагчлал, кабель шугамын байгууламжийг зөөж шилжүүлэх төсвийн тооцоо болон холбооны худал сувагчлал, кабелийн байгууламжийг шилжүүлэх, хамгаалах техникийн болон ажлын зурга боловсруулах даалгавар батлуулсан. Хавсралт : 6 файл	90%
15	9. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшигчийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээг зохион байгуулна.	2021	-	Шуудангийн тухай хуулийн 6.1.5-д заасны дагуу Шуудангийн үндсэн сүлжээ ашиглах эрх олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/87 дугаар тушаалаар байгуулсан. Сайбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор журмын төслийг Засгийн газрын хуралдаанд, хэлэлцүүлгээсээ 2024 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1196 дугаартай албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	70%

16	10. Шуудан, логистик, цахим худалдааны даамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.	2020 - 2022	-	-	1. Азийн Хөгжлийн Банктай 2021 оны 11 дүгээр сард байгуулсан бүс нутгийн "Цахим эдийн засгийн тогтвортой орчныг бүрдүүлэх" санаж бичгийн хүрээнд Монгол Улс дахь цахим худалдааны хууль эрх зүй, зохицуулалтын саад баршээлийг тодорхойлж, сайжруулах зөвлөмжийг боловсруулах судалгааны ажлын хүрээнд 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдөр ГХЯ, ХХЗХ, АХБ-тай хамтран төр, хувийн хэвшлийн 80 орчим төлөөллийг оролцуулан "Цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал" хэлэлцүүлгийг зохион байгуулж, үр дүн, судалгааны тайлант нэгтгэсэн. Судалгааны эхний тайланттай 2022 оны 11 дүгээр сард танилцаж, саналаа хүргүүлсэн. 2.НҮБ-аас Дижитал эдийн засаг, цахим арилжааны хөтөлбөрийн чадавхийг бэхжүүлэх ажлын хүрээнд Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн Газар, Европын Сэргэн Босголын Банк, Хөгжлийн банк хамтран Монгол Улсын цахим худалдааны бэлэн байдлын үнэлгээг хийх Гадаад харилцааны яамнаас байгуулсан ажлын хэсэг ажиллаж, 2022 оны 06 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Гадаад харилцааны яамнаас зохион байгуулсан Үндэсний олон талт зөвлөлдөх уулзалтад оролцож, Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдлын талаар хийсэн эхний тайланттай танилцаж, судалгааны ажлын даалгаварт санал өгсөн. 3.Азийн Хөгжлийн Банкны санхүүжилтээр цахим худалдааны статистикийг сайжруулах зөвлөх үйлчилгээг хийлгэж байгаа бөгөөд эхний тайлант хүлээн авсан. 4.Монгол Улсын цахим худалдааны өнөөгийн нөхцөл байдал, цахим худалдаа болон шуудангийн үйлчилгээ эрхэлгэдийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудал, боломж, төрөөс үзүүлэх дэмжлэг зэрэг асуудлаар санал бодлоо солилцож, шийдэл боломжийн талаар хэлэлцэх зорилгоор "Цахим худалдаанд үзүүлэх дэмжлэг" хэлэлцүүлгийг 2024.06.04-ний өдөр зохион байгуулаа. Хэлэлцүүлэгт цахим худалдаа, цахим платформ, хүргэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч компаниуд болон төрийн байгууллагын 100 орчим төлөөлөл оролцов. Хэлэлцүүлгийн үеэр зөвлөмж гарган оролцогч байгууллагуудаас санал авахаар хүргүүлээд байна. Хавсралт : 3 зураг	100%
17	11. Шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулж, хэрэглээг цахим худалдаанд нэвтрүүлнэ	2020 - 2022	-	-	Харилцаа холбооны зохицуулах хорооноос гаргасан шуудангийн нэгдсэн кодыг бусад платформууд (ARF, Shorpu.mn, zochil.mn)-д холбохоор тохиролцож, холбох ажлыг хийж байна. Нэгдсэн кодын холболт хийх ажлыг Бодь электроникс ХХК хариуцаж байгаа бөгөөд Харилцаа холбооны зохицуулах хороо ажлыг хүлээн авч байна. Мөн нэгдсэн кодыг хэрэглээнд нэвтрүүлэх, олон нийтэд таниулах хэлэлцүүлгийг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдөр цахим худалдааны 56 байгууллагад зохион байгуулж, хэлэлцүүлгээс зөвлөмж гарган танилцуулсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 180 дугаар тогтоолын дагуу 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга, хот байгуулалтын яамтай хамтран төрийн болон хувийн хэвшлийн 30-аад байгууллагыг хамруулан хаялжилтын асуудлыг шийдвэрлэх нэгдсэн системтэй болох зорилгын хүрээнд "Газар, үл хөдлөх хөрөнгийн ханжуулалт-Орон зайн өгөгдлийн дэд бүтэц" сэдэвт уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтын үр дүнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон Барилга, хот байгуулалтын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нарын хамтарсан тушаал гарч, ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгийн төлөвлөгөөний дагуу зип код, шуудангийн кодыг Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн сантай тулгах, нэгтгэх ажил хийгдэж байна.	90%
18	12. Үндэсний хиймэл дагуул хөөрөгх хууль эрхзүйн бүрдүүлнэ	2021 - 2024	-	-	Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийн төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг баталсан. Сансрын тухай хууль, тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 34 асуужийг боловсруулж, 37 байгууллагад хүргүүлэн санал авч судалгааг хийсэн. Мөн 23 орны сансар судлалтай холбоотой хууль, бодлогын баримт бичгийг судалсан. Хавсралт : 7 файл	30%

19	13. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулна.	2020 - 2022	Орон даяар өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй нийт телевиз радиог холболтын нэгдсэн төвийн сүлжээнд холбосон байна.	Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холболтын нэгдсэн төв байгуулах төслийн судалгааг 2021 оны 4 дүгээр улиралд шинэчлэн хийсэн ба 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд санал өгсөн. Тус судалгааг хийснээр төрөөс байгуулах телевизийн сүвгүүдийг нэг цэгт төвлөрүүлж, нягтруулж эфирт цацах, улмаар гамшигын үеийн зарлан мэдээлэл, зөвлөмжийг нэг цэгээс олон нийтэд шуурхай дамжуулах боломж бүрдсэн. Мөн орон даяар дамжуулах телевизийн өргөн нэвтрүүлгийн чанарт хяналт тавих боломж бүрдэхээр төлөвлөөг хийсэн. Олон сүлгийн дамжуулах үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий компаниуд өргөн нэвтрүүлгийн төлөвс бүртэй тусдаа давхардсан холбогт хийх шаардлагагүй байхаар төслийн техникийн төлөвлөгөөнд тусгасан. Хяналтын нэгдсэн төв байгуулснаар бүх өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ болон контент нэвтрүүлэлт нэг удирдлага дор орох эрсдэлтэй байх тул энэхүү төвийг байгуулахгүй байх дүгнэлт гарсан. Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалтын дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар баталсан "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшигын болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам"-ын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр Онцгой байдлын ерөнхий газартай хамтран өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшигын үеийн мэдээлэл дамжуулах нэгдсэн системийн холболтын цэгт Монголсат нэвтрөгч ХХК-ийг холбосон.	70%
20	1. Үндэсний мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэд бүтцэд халдах, эдийн засаг, нийгмийн чадавхыг сулруулах зорилготой халдлагыг илрүүлэх, таслан зогсоох, харму үйлдэл, чадавхыг зорилгоор бүхжүүлэх зорилгоор Цахим мэдээллийн байдлын хяналт удирдлагын төв (CERT) байгуулна.	2021 - 2024	Үндэсний хэмжээнд мэдээллийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бий болж, иргэн, байгууллагууд мэргэжил, арга зүйн тусалцаа авах боломж бүрдэж мэдээллийн аюулгүй байдал сайжирна.	Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 319 дүгээр тогтоолоор "Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлуулсан. Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциацийтай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд "Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв"-д шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжийг худалдан авах ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТГ-ыг Монгол Улсын хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ олгосон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг томилсон. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн А/122 дугаар тушаалаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв улсын төсөвт үйлдвэрийн газрын бүртгэлд 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр бүртгүүлж, улсын бүртгэлийн 9068001076 дугаартай гэрчилгээ олгосон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн Б/48 дугаар тушаалаар кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн захирлыг томилсон. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 04-20-ны өдрийн Б/1-Б/8 дугаар бүхий тушаалаар нийтийн төвийн 8 ажилтныг томилж үйл ажиллагааг эхлүүлээд байна. Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төв УТГ нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй хувийн хэвшлийн байгууллага, ирэнд, чиглэсэн кибер халдлага, зөрчилтэй тэмцэх, халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, харму арга хэмжээ авах, бүх нийтийн кибер аюулгүй байдлыг хангах мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Кибер аюулгүй байдлыг хангах гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэхээр энэ чиглэлийн үйл ажиллагаатай FIRST олон улсын байгууллагад гишүүнчлэлтэй болж, кибер халдлага, зөрчлийн талаарх мэдээлэл солилцон ажиллаж байна.	100%

	4.1.6. Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн тогтолцоог бэхжүүлж, чадварыг нэмэгдүүлнэ.	2. Монгол Улсын хэмжээнд интернэтийн хангжилтыг 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ		Төрийн байгууллагуудын тоног төхөөрөмжүүдийг шинэчилж, төрийн байгууллагуудын интернэт хэрэглэгчдийн 24 хувийг шилжүүлсэн байна.	Цахим хөгжилт, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны А/03 дугаар тушаалаар Монгол Улсын хэмжээнд интернэтийн хангжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг нь Монгол Улсын хэмжээнд интернэтийн хангжилтыг 6 дахь /IPv6/ хувилбарт шилжих төлөвлөгөө боловсруулан Ази, Номхон Далайн бүсийн Сүлжээ Мэдээллийн Төв (APNIC)-тэй хамтран 2023 оны 02 дугаар сарын 06-09-ний өдөр салбарын инженер техникийн ажилтан, удирдах албан тушаалтныг хамруулан "Монгол Улсын интернэтийн сүлжээг интернэт хаягжилтын IPv6 хувилбарт шилжих төлөвлөгөөний талаарх хэлэлцүүлэг"-г нээлттэй танилцуулж, хэлэлцүүлсэн. "Монгол Улсын хэмжээнд интернэтийн хангжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх төлөвлөгөө"-ийг хэрэгжилтийг хангуулахад Харилцаа холбооны зохицуулах хороонд 2023 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 02/441 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Мөн Монгол Улсын хэмжээнд интернэтийн хангжилтын 4 дэх (IPv4) хувилбараас 6 дахь (IPv6) хувилбарт шилжүүлэх яамдын болон харьяа байгууллагуудын багын байдлын аюулгүй 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 03/870 дугаартай албан бичгээр 15 яаманд хүргүүлж, 65 байгууллагаас судалгаа авч, судалгааны үр дүнг нэгтгэсэн. Үндэсний дата төв УТҮГ-г төрийн байгууллагуудын интернэт хаягжилтыг 6 дахь хувилбарт шилжүүлэх ажлыг эхлүүлэх чиглэлтэй 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 03/2016 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Үндэсний дата төв УТҮГ-ын харьяанд ажилладаг Монголын интернэтийн үйлчилгээ үзүүлэгчдийн сүлжээ (МНХ)-д IPv6 dual stack тохиргоогоор 9 интернэт үйлчилгээ үзүүлэгч байгууллага холбогдсон байна. Монгол Улсын гадаад гарцаар олон улс руу IPv6 хаягжилтаар гарч байгаа траффикын хэмжээ 38.35%-д хүрсэн. Үндэсний дата төв УТҮГ-ын цахим хуудас байршуулах үйлчилгээнд IPv6 хаягийг нэвтрүүлж, төрийн байгууллагын үндсэн 800, дэд 800, нийт 1600 цахим хуудсыг IPv6 хаягтай болгох ажлын төлөвлөгөөг боловсруулж байна. Хавсралт нийт : 14 Файл : 8 Зураг : 6	90%
22		3. Үндэсний хэмжээний мэдээллийн аюулгүй байдлыг хангах сургалтын тогтолцоог бий болгоно.	2021 - 2024	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 9000 төрийн албан хаагчийг чадваржуулсан байна. Улсын хэмжээнд нийтийн сүлжээгээр иргэдэд контент түгээж бүрэн хамруулсан байна.	Интернэтийн үйлчилгээ эрхлэгч 24 компанид "Харилцан мэдээлэл солилцох Протоколд нэгдэх" сургалтад 2024.01.05-ны өдөр 28 албан хаагчийг хамруулсан. Кибер халдлага зөрчилд хариу үзүүлэх "ТАСТИС" команд штабын хамтарсан сургуулийг 7 байгууллагын 80 албан хаагчдад 2024.01.12-13-ны өдөр зохион байгуулсан. "Кибер аюулгүй байдлын төлөвлөлтийн заавар стандарт 2024" сургалтад 2024.01.25-ны өдөр 119 алба хаагчийг хамруулсан. Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрын орон нутаг дахь хэлтсийн дарга нарт Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам, мэдээллийн аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт, эрсдэл ба эмзэг байдлын талаарх сургалтыг 2024.01.17-ны өдөр зохион байгуулсан. "Кибер аюулгүй байдлын мэргэжилтний дэдлагажуулах" сургалтад 2024.02.29-ний өдөр 16 байгууллагын 60 мэргэжилтэн хамруулсан. Япон Улсын Токио хотноо "Кибер аюулгүй байдлын хүний нөөцийг хөгжүүлэх" сургалтад Монгол Улсаас 16 албан хаагч 2024.02.14-21-ний өдөр оролцсон. АНУ-ын MITRE байгууллагатай хамтран "Онц чухал дэд бүтцийг эрэмбэлэх-2" сургалтад 2024.03.27-28-ны өдөр онц чухал дэд бүтцийн аюулдал хариуцсан 26 алба хаагч, мөн "Ransomware" халдлагад "NIST CSF Profile" болон тэрүүлэх аргачлалыг ашиглах нь сэдэвт сургалтад 2024.04.02-04-ний өдөр 24 байгууллагын 27 албан хаагчийг хамруулж, сертификат олгосон. Дэлхийн Банк болон "NRD" байгууллагатай хамтран 2024.04.10-12-ны өдөр "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн удирдлагын хүрээ" сэдэвт сургалтад 45 байгууллагын 45 албан хаагч хамрагдсан. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй 76 байгууллагын албан хаагчийг 2024.04.30-ны өдрийн сургалтад хамруулсан. "Цахимд хэвшье" #Digital_First_D1 арга хэмжээг 2024.03.11-05.03-ны хугацаанд 21 аймгийн төрийн албан хаагчдад "Кибер аюулгүй байдлын хууль, эрх зүйн орчин" сэдэвт сургалтад 6653 албан хаагчийг хамруулсан. И-Монгол академи УТҮГ-аас Мэдээллийн аюулгүй байдал сэдэвт 22 удаагийн танхимын сургалтад 1321 албан хаагч, нийт 8472 албан хаагчийг мэдээлэл аюулгүй байдлыг хангах чиглэлээр чадваржуулсан байна. Хавсралт нийт : 15 Файл : 8 Зураг : 7	100%

23	1. Мэдээлэл, холбооны өндөр технологийн инновацийн кластер байгуулна	2021 - 2022		Мэдлэг шингэсэн, экспортын чиг баримжаатай өндөр технологи, инновацийн үйлдвэрлэл, үйлчилгээний секторыг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлсон байна.	Тус яамнаас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 3.5-д 3.1.5 Шинэ Хархорум хотод өндөр технологи, инноваци бизнес хөгжлийн төв байгуулах ТЭЗГ-г боловсруулах саналыг 2025 оны төсвийн төсөл, 2026-2027 оны төсвийн төсөөлөлд хүргүүлсэн. Түүнчлэн тус саналд Мэдээллийн технологийн тухай хуулийн 6.1.4-т мэдээллийн технологийн виртуал бүс байгуулах гэж заасан, 6.1.8-д тусгасны дагуу хиймэл оюун ухаан, их өгөгдөл, сансрын үйлдвэрлэлийн дээшилтээ технологиод суурилсан сэндбоксн журмыг батлах гэж заасны дагуу тус чиглэлийн судалгаа шинжилгээг сайжруулах зорилгоор Сэндбокс орчин бий болгох болон Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүс байгуулах судалгаа хийх төслүүдийг оруулсан. Хавсралт : 1 файл	30%
24	2. МХХТ-ийн хэрэглээний өрх болон хувь хүний судалгааг хийнэ	2021 - 2024		Улсын хэмжээнд нийт 13000 өрхийг хамруулсан МХХТ-ийн хэрэглээний судалгаа хийгдсэн байна.	2022 онд "Хувь хүн болон өрхийн мэдээлэл, харилцаа холбооны хэрэглээний судалгаа"-г Үндэсний статистикийн хороотой хамтран Улсын хэмжээнд 13000 өрхийг хамруулан хийсэн. Тус судалгааны үр дүнг цахим хэлбэрээр Үндэсний статистикийн хорооны цахим хуудас (www.1212.mn) болон Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудас (www.mnps.gov.mn)-г нээлттэйгээр байршуулж, олон нийтэд хүргэсэн. Мөн судалгааны ботийг 400 ширхэг хэвлүүлэн салбарын байгууллагууд болон олон нийтэд түгээсэн. Уг судалгаа нь 2022 онд 120 сая төгрөгөөр хийгдсэн, Улсын хэмжээнд нийт 13000 өрхийг хамруулсан "МХХТ-ийн хэрэглээний судалгаа"-г 2024 онд хийхээр төлөвлөсөн боловч төсөвт тусгаадаагүй тул судалгааг хийх боломжгүй байна. Хавсралт : 1 файл	30%
25	3. Инноваци, Мэдээллийн технологийн салбарыг экспортод чиглүүлсэн дигитал эдийн засгийг хөгжүүлэх, судалгаа, шинжилгээний институтыг бэхжүүлнэ.	2021 - 2024			1.Тус яаманд Судалгаа, шинжилгээний хэлтэс, И-Монголиа академи УТУГ-ын бүтцэд Мэдээллийн технологийн инноваци, судалгаа, сургалтын хэлтсийг тус тус байгуулав 2.Цахим шилжилт, дигитал эдийн засгийг Харилцаа холбоо мэдээлэл технологийн дэд бүтцээр дэмжих, харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээ хүрээгүй баг, суурин газрын судалгаа, хөдөлгөөнт холбооны 2 болон 3 дахь үе (2G, 3G)-ийн нэвтрэлтийн өнөөгийн байдлын судалгаа, өргөн нэвтрүүлгийн талаарх бодлогын судалгааг БНСУ-ын судалгаа, хөгжлийн байгууллага KISDI-тэй хамтран хийсэн. 3.Хиймэл оюун ухааны төлөөр баримтлах төрийн бодлого, хууль эрх зүйн орчны талаар судалгаа хийгдсэн. 4.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай анхдагч хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2024 оны 05 дугаар сарын 14-ний өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулсан ба харилцаа холбоо, мэдээллийн технологи, финтек болон гарааны бизнес эрхлэгчдийн 300 гаруй төлөөллийг оролцуулж хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг нэгтгэсэн. Инноваци, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хэлэлцүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хуралдаанаар батлагдсан. Хавсралт : 2 файл	100%
26	4.1.7. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, үр чадварыг дээшлүүлнэ.				1.И-Монгол академиаас 2022-2023 онд нийт 39431 иргэдэд цахим ур чадвар олгох сургалтын зохион байгуулсан байна 2.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (E-Mongolia) хуушад хамгааллын (E-Kids), "Цахим ур чадварын үндэсний аян"-ыг сурталчилсан таниулах 7 удаагийн арга хэмжээ зохион байгуулсан. Цахим ур чадварын үндэсний аяныг Чингэлтэй дүүрэгт 04 дүгээр сарын 27-ны өдөр, Чингис хааны үндэсний музейд "DIGITAL YOUTH", "Цахим ур чадварын үндэсний аян-УБ марафон", "Цахимд хэвшье" DIGITAL FIRST-D1 арга хэмжээ, "Хуушад таныг хамгаалъя", "Технологитор гэр бүлээ хамгаалъя E-kids" нээлттэй өдөрлөг зэрэг үйл ажиллагааг зохион байгуулав. 2.Төрийн цахим үйлчилгээ зохицуулалтын газраас 2023-2024 оны эхний хагас жилийн байдлаар нийт 30,944 иргэдэд цахим ур чадвар олгох сургалт зохион байгуулсан байна. Бүх нийтийн цахим ур чадвар олгох сургалтын хүрээнд 2022-2024 онд нийт 70,375 иргэдийг хамруулсан байна. Хавсралт : 10 файл	100%


27	6. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан албан хаагчдад мэргэжлийн үр чадвар олгох мэргэшүүлсэн сургалтуудыг зохион байгуулна.	2021 - 2023			Тус яамнаас 2023 онд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын ажилтан, албан хаагчдад мэргэжлийн үр чадвар олгох 16 удаагийн сургалтыг зохион байгуулж, 852 албан хаагчийг, И-Монгол академи УТУГ-аас мэдээлэл, харилцаа холбоо, технологийн салбарын нийт 808 ажилтан, албан хаагчийг тус тус хамруулж, 1660 албан хаагчдад сургалт зохион байгуулсан. "Харилцан мэдээлэл солилцох Протоколд нэгдэх нь" сэдэвт сургалтыг 2024.01.05-ны өдөр зохион байгуулж, интернэтийн үйлчилгээ эрхлэгч 24 компанийн 28 албан хаагчийг хамруулсан. "Кибер аюулгүй байдлын мэргэжилтнийг даялгажуулах нь" сэдэвт сургалтыг 2024.02.29-ний өдөр зохион байгуулж, 16 байгууллагын 60 ажилтныг хамруулсан. АНУ-ын MITRE байгууллагатай хамтран "Онц чухал дэд бүтцийг эрэмбэлэх нь-2" сэдэвт сургалтыг 2024.03.27-28-ны өдрүүдэд зохион байгуулж, онц чухал дэд бүтцийн асуудал хариуцсан 26 алба хаагчийг, "Ransomware халдлагад NIST CSF Profile болон тэргүүлэх аргачлалыг ашиглах нь" сэдэвт сургалтыг 2024.04.02-04-ний өдөр зохион байгуулж, 24 байгууллагын 27 албан хаагчийг тус тус хамруулж, сертификат олгосон. Дэлхийн Банк болон "NRD" байгууллагатай хамтран 2024.04.10-12-ны өдрүүдэд "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үүрдлэлийн хүрээ" сэдэвт сургалтыг зохион байгуулж, 45 байгууллагын 45 алба хаагчийг хамруулсан. Онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллагын жагсаалтад багтсан 76 байгууллагын кибер аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа хариуцсан ажилтнуудад зориулан 2024.04.30-ны өдөр "Кибер халдлага зөрчлөөс хамгаалах нь" хэлэлцүүлэг зохион байгуулсан. Мөн дээрх байгууллагын 20 ажилтныг 06 дугаар сарын 10-18-ны өдрүүдэд Advanced Web and Operating System Security сургалтад, 17 ажилтныг 06 дугаар сарын 19-24-ний өдрүүдэд "Кибер аюулгүй байдлын засаглал ба аудит" сэдэвт сургалтад тус тус хамруулсан. 2024 оны эхний хагас жилийн байдлаар салбарын 299 ажилтныг сургалтад хамруулсан байна. 2023 онд нийт 1959 албан хаагчдад үр чадвар олгох, мэргэшүүлэх сургалтад хамруулсан байна. Хавсралт : 12 файл
28	1. Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах тэсүү боловсруулна.	2021 - 2022			Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газраас 2021 оны жилийн эцсийн байдлаар "Үндэсний контент үйлдвэрлэлийн төв байгуулах" төслийн танилцуулга, урьдчилсан тооцооглыг Сангийн яам, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Бүгд Найрамдах Солонгос Улс болон Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбоо технологийн хамтын ажиллагааг дэмжих, Монгол Улсын МХХТ-ийн хүртээмж, үр чадварыг сайжруулах зорилгоор "Цахим үр чадвар олгох төв"-ийг Бүгд Найрамдах Солонгос Улсын хөрөнгө оруулалтаар Мэдээлэл технологийн үндэсний паркыг түшиглэн байгуулсан. Цахим үр чадвар олгох төв нь хурлын өрөө, интернэт өрөө, тус бүр 16 иж бүрэн компьютер бусад тоног төхөөрөмжийн бүрдэл бүхий мэдээлэл, харилцаа холбооны технологийн сургалтын 2 танхим, тоон контент бүтээх, контент бүтээгчдийг дэмжин хөгжүүлэх 2 танхим, захиргааны албан өрөөнөөс бүрдэх нийт 360м² танбай бүхий цогц байгууламж юм. Хурлын өрөө, интернэт өрөө нь ирээдэд интернэт орчинд мэдээлэл солилцох, харилцах, бие даан суралцах боломж олгох, сургалтын танхимуудад иргэдийн цахим боловсролыг дээшлүүлэх сургалтуудыг зохион байгуулж, тэднийг цахим орчинд ажиллах, суралцах мэдлэг чадвар олгож тэдний цаашдын хөгжлийг дэмжих үрт хугацааны ач холбогдолтой юм.
29	4.1.9 Мэдээллийн технологийн энтрепренёр, гараны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.	2021 - 2024			Мэдээлэл технологийн үндэсний парк ААТҮГ-ыг түшиглэн Мэдээлэл, хандлагын төвийг байгуулахаар шийдвэрлэж, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас засвар үйлчилгээний ажил, холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэн "Мэдээлэл хандлагын төв"-ийг байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Үг төвд цахим үр чадвар чадмжийг дээшлүүлэх сургалтын 2 танхим, контент хөгжүүлэлтийн 2 танхим, конференцын 1 танхим, интернэт үйлчилгээний 1 танхим, нийт 6 танхимыг хүлээн авах хэсгийн хамт тохижуулж, тоноглогсон. Энэхүү төвийн контент хөгжүүлэлтийн танхимд үндэсний контент хөгжүүлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, бүтээсэн контентыг олон нийтэд сурталчлах зэрэг үйл ажиллагааг явуулахаас гадна олон нийт болон хөгжлийн бэрхшээлтэй ирээдэд сургалт хийх зориулалтай. Бүсчлэсэн контент үйлдвэрлэлийн төв байгуулах төсөв тусгагдаагүй тул төвийг байгуулах боломжгүй байна. Хавсралт : 1 файл
					100%
					90%
					30%

30	3. МХХТ-ийн салбарын энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтран ажиллана.	2021 - 2024		Олон улсын ижил төстэй байгууллагуудтай хамтран ажиллаж, бүс нутгийн хэмжээнд энтрепренёр болон гарааны бизнесийг хөгжүүлэх эко систем бий болгон байна	1.Энтрепренёруудыг дэмжих чиглэлээр Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага (ЖАЙКА), Япон Улсын Deijotte зөвлөх үйлчилгээний компанигай хамтран "Нээлттэй өвгөдөл ашиглах хөтөлбөр боловсруулах" төслийн багийн цахим уулзалтад 2024 оны 05 дугаар сарын 01, 08, 15, 22-ны өдөр холбогдох мэргэжилтнүүд оролцож, нээлттэй өвгөдөл ашиглан зохион байгуулах Хакатоныг 2024 оны 08 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна- 2.Мөн хугацаанд Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих бүс байгуулахад хамтран ажиллах чиглэлээр Арабын Нэгдсэн Эмират Улс, IT Start up буюу мэдээллийн технологийн салбарын гарааны бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээг тануулах, хөгжүүлэх/дэмжлэг үзүүлэх хүрээнд хамтран ажиллах чиглэлээр Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Бүгд Найрамдах Киргиз Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, мөн Төв Азийн улсууд хамтран Америкийн Нэгдсэн Улсын Цахиурын хөндийд "Торгоны замын инновацийн төв" байгуулснаар гарааны компаниуд олон улсын зах зээлд гарах үүд хаалтыг нээж өгөн бөгөөд үүнтэй холбогдуулан хамтарсан венч сан байгуулж, гарааны компануудаа дэмжих талаар өргөн хүрээнд хамтран ажиллах талаар санал солилцон ажиллаж байна. 3.Мэдээлэл технологийн парктай хамтран ажиллах чиглэлээр Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс (Умард Солонгос), Франц Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Монгол Улсын програм хангамж хөгжүүлэгч болон мэдээллийн технологийн бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлан тануулах, мэдээллийн технологийн аугсгоринг хийх боломжийг судлах, гарааны бизнесийг дэмжих экосистемийн талаар туршлага судлахад хамтран ажиллах чиглэлээр Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс, Узбекистан Улстай хамтран ажиллах санажм бичиг, урьдчилсан яриа хэлэлцээ хийсэн	100%
31	4.1.9. Мэдээллийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна.	2020 - 2023		Бүс нутгийн болон олон улсын оюуны өмчийн системтэй холбогдож, Монгол оюуны өмчийг олон улсын хэмжээнд эдийн засгийн эргэлтэнд оруулах, гадаадын хөрөнгө оруулалт татах боломж бүрдсэн байна	1.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд 2024 оны 01 дүгээр сард АНУ-д айлчлах үеэр Төв Азийн улс орнуудтай хамтарсан санаачилгын хүрээнд, хэрэгжиж байгаа Торгоны зам инновацийн төвд албан ёсоор Монголын мэдээллийн технологийн салбарын тэргүүлэгч 8 компанийг байршуулж, Цахиурын хөндийн экосистемд бойжуулах эхлэлийг тавив 2.Испанийн Хаант Улсын Барселон хотод 03 сард зохион байгуулагдсан "Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024"-т Монгол Улсын төр, хувийн хэвшил хамтран анх удаа асар барьж, Монгол Улсын цахим шилжилт, технологийн хөгжил, дэвшилг сурталчлан тануулж, тус салбарын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг дэлхийн улс орнуудад сурталчилсан. 3.Мэдээллийн технологийн үндэсний парк ТӨААТҮГ-ын дэргд гарааны бизнесийн экосистемийн оролцогч, хөрөнгө оруулагчдын төлөөллөөс бүрдсэн Гарааны бизнесийн зөвлөлийг 2024.03.18-нд байгуулсан. Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага ЖАЙКА-тай МХХТ-ын салбарын гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр хамтран ажиллах төлөвлөгөөнд санал хүргүүлсэн. 4.Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын дэмжлгээр хийгдэх "Нээлттэй өвгөдөл ашиглах хөтөлбөр боловсруулах" төслийн багийн уулзалтад 2024 оны 05 дугаар сарын 01, 08, 15, 22, 06 дугаар сарын 08, 15,19-ний өдөр холбогдох мэргэжилтнүүд цахимгаар оролцож, нээлттэй өвгөдөл ашиглан зохион байгуулах Хакатоныг 2024 оны 08 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн бэлтгэл ажлыг хангаж байна. Энэхүү арга хэмжээний хүрээнд шалгарсан 2 баг Япон Улсаас хөрөнгө оруулалт татах боломжтой бөгөөд тэмцээний шаналд 6500 ам.долларын шангал хүртэх юм. 5.Төрийн үйлчилгээний нэгдсэн систем (www.E-Mongolia)-д оюуны өмчийн дараах үйлчилгээнүүдийг нэвтрүүлсэн, үүнд: 1.Зохиогчийн эрхийн гэрчилгээ дахин авах; 2.Зохиогчийн эрхийн гэрчилгээний хуулбар авах; 3.Зохиогчийн эрхийн эрх шилжүүлэх хүсэлт гаргах; 4.Оюуны өмчийн зохиогчийн эрхийн лавлагаа; 5.Оюуны өмчийн итгэмжлэгдсэн төлөөлчийн үйл ажиллагаа эрхлэх; 6.Оюуны өмчийн бүтээлийн хүсэлтийг хүлээн авах Хавсралт : 2 файл	90%

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, ХҮРЭХ ТҮВШИНГ ТАЙЛЛАНАХ ХҮСНЭГТ

Дугаар	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үндсэн хэрэгжүүлэх байгууллага	Сурь түвшин	2021				2022				2023				2024		Зорилтот түвшиндээ хүрээгүй шалтгаан, нөлөөлсөн үүсвэр/үйсдийн талаарх тайлбар
					Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжил-тийн хувь	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжил-тийн хувь	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжил-тийн хувь	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Хэрэгжил-тийн хувь	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15	16	17	18		
98	Иргэдэд тоон гарын үсэг олгож, харилцаанд оролцсон иргэний тоо	тоо	ЦХХХЯ	23000	-	-	-	-	503802	100	123000	899802	100	173000	1150658	100	Монгол Улсын хэмжээнд 2024 06 сарын 26-ны байдлаар нийт 1150658 тоон гарын үсгийг иргэдэд олгож, харилцаанд оролцсон байна. Үүнээс Хүснэгт бүртгэлийн ерөнхий газар 138 686 тоон гарын үсгийг олгоод байна.		
99	Төрийн байгууллагын Е-Монгола платформд холбогдох төрийн байгууллагаас цахим хэлбэрээр үзүүлж байгаа үйлчилгээний тоо	тоо	И-Монгол академий УТҮГ	181	261	606	100	341	806	100	421	1130	100	501	1251	100	2021. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөхөтөл баг, Архангай аймгийн Хашаат сумыг шилэн кабелийн сүлжээнд холбохоор нийт 666 сая төгрөгийг төсөвлөснөөс Архангай аймгийн Хашаат сумыг шилэн кабелинд холбох ажлыг Нотсан ХХК-иар гүйцэтгэж, 2021 оны 10 дугаар сард байнгын ашиглалтад оруулах комисс ажиллаж ажлыг хүлээн авсан. Харин Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөхөтөл багийг шилэн кабелинд холбох, зураг төсөв боловсруулах ажлыг 2021, 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн тул он дамжин хийгдэх болсон. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр Хэнтий аймгийн Өмнөдэлтэр сумын Гурван-Баян Улаан, Дэлгэрхаан сумын Хэрлэн-Баян Улаан, Булган аймгийн Хангал сум, Хөлгөнгов тосгонч тус тус шилэн кабелийн сүлжээнд холбогсон. 2021 онд Улсын төсөв болон бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн нийт хөрөнгө оруулалтаар 151 км урт шилэн кабелийг шинээр суурилуулсан.		
100	Шилэн кабелийн сүлжээнд холбох сум суурингийн тоо	тоо	ЦХХХЯ	320	2	1	50	3	2	75	3 сум, 5 боомт	-	-	-	-	70	2022. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд шинээр шилэн кабелийг төсөл, арга хэмжээ баталдаггүй. Харин 2021 оноос шилжсэн "Шилэн кабелинд холбох, зураг төсөв боловсруулах Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөхөтөл баг" арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн боловч тухай онддоо бүрэн дуусгаагүй. Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймгийн Алтай сум, Дорнод аймгийн Халх гол сумыг шилэн кабелийн сүлжээнд холбогсон. 2022 онд нийт 282,2 км шилэн кабелийг шинээр суурилуулсан.		

Цахим хэржил, харилцаа холбооны саямдын
2021 оны 6 сарын 26-ны өдрийн 155 дугаартай
албан-бичгийн 2 дугаар хавсралт.



4.1.4	Төрийн үйлчилгээнд, хариуцаа мэдээлэл, холбооны технологийн давшил, инноваци, нэвтрүүлэх замаар бүтээж, үр ашгийг дээшлүүлнэ	2. Засгийн газрын тусгай сангуудын үйл ажиллагааг иргэд, хувийн хэвшлийн дэмжихэд чиглүүлэн, олон нийтэд нээлттэй, ил тод, хяналттай тогтоолонд бүрэн шийжүүлсэн цахим систем бий болгоно	2021	Улсын төсөв	-	300.0	-	200.0	100	-	200.0	200.0	100	2023 онд төсөв батлагдаагүй тул ажил зогссон. Мөн 2021 оны гэрээг шинэчлэн байгуулах шаардлага үүссэн				
8	1. Сүм, суурин газрыг шилэн кабелийн сүлжээнд холбоно.		2021-2022	Улсын төсөв	8,000.0	850.00	650.00	76.50	184.00	34.10	18.50	-	165.90	0	0	600.00	5,077.4	79.66
9	2. Аймгуудад өгөгдөл мэдээллийн зангилаа төв байгуулна.		2021-2024	Улсын төсөв	9,000.0	-	-	-	6,500.00	420.0	6.6	5,953.70	4,637.2	70.8	1,736.50	5,077.4	79.66	
10	3. Үндэсний дата төвийн техник, хүчин чадлыг сайжруулна.		2021-2022	Улсын төсөв	40,000.0	-	-	-	20,000.0	-	-	10,000.0	7,300.0	100	-	-	7,300.0	7,300.0
11	4. Халдварт холбооны 5 дахь үеийн системийг нэвтрүүлнэ.		2022-2023	Улсын төсөв	550.0	-	-	-	250.0	-	-	150.0	-	-	-	-	400.0	-
12	5. Тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулна.		2021-2023	Улсын төсөв	12,100.0	-	-	-	12,100.0	-	-	-	-	-	-	-	-	-
13	4.1.5. Бүх нийтийн холбооны хариуцаа мэдээлэл, хариуцаа үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж хэмэрэх, батламжийг нэмэгдүүлнэ.		2021-2023	Улсын төсөв	3,590.0	-	-	-	1,690.0	-	-	900.0	-	-	-	-	2,590.0	-
14	8. Хариуцаа холбооны дэд бүтцийг эрчим хүч, зам, замын байгууламж, зэрэг бусад инженерийн дэд бүтэцтэй уялдуулан төлөвлөнө.		2021-2024	Улсын төсөв	50.0	25.0	-	-	25.0	-	-	-	-	-	-	-	50.0	-
15	9. Шуудангийн үндсэн сүлжээ эзэмшлийн бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох арга хэмжээ зохион байгуулна.		2021	Гадаад дотоод хөрөнгө оруулалт /хувийн хэвшил/	50.0	-	-	-	50.0	-	-	-	-	-	-	-	50.0	-
16	10. Шуудан, логистик, цахим худалдааны дамжуулах чадварыг өргөтгөн, сайжруулах арга хэмжээ зохион байгуулна.		2020-2022	Улсын төсөв	50.0	20.0	-	-	30.0	-	-	-	-	-	-	-	50.0	-
17	11. Шуудангийн нэгдсэн кодыг олон нийтэд таниулж, хэрэглээг цахим худалдаанд нэвтрүүлнэ.		2020-2022	Улсын төсөв	10.0	10.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	10.0	-
18	12. Үндэсний хиймэл дагуул хөөрөгч хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.		2021-2024	Улсын төсөв	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
19	13. Өргөн нэвтрүүлгийн радио, телевизийн холбоолтын нэгдсэн төв байгуулна.		2020-2022	Улсын төсөв	3,800.0	-	-	-	-	-	-	3,600.0	-	-	-	-	3,600.0	-
20	4.1.6. Үндэсний ашиг сонирхлыг төр, иргэд, хувийн үзүүлэх чадварыг зорилгоор Цахим мэдээллийн бүрэн аюулгүй байдлын хяналт үндэслэл, хуртээжтэй байдлыг хангасан мэдээллийн тогтолцоог бүтээж, үр ашгийг дээшлүүлнэ.		2021-2024	Улсын төсөв	23,390.0	-	-	-	13,390.0	-	-	5,000.0	-	-	-	-	18,390.0	-
21	2. Монгол Улсын хэмжээнд интерактивийн хөгжилтийг 6 дахь (IPv6) хувийнбарт шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.		2021-2024	Улсын төсөв	1,080.0	-	-	-	380.0	-	-	350.0	-	-	-	-	730.0	-

[illegible]

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ХӨТӨЛБӨРИЙН ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2024.06.27

№

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний гол зорилго нь төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам" болон холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн акт заавар журмыг үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, дутуу гүйцэтгэлийг арилгуулах талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд үндсэн зорилго оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасны дагуу албан хаагчдын төлөвлөгөөнд заасан зорилт арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан үнэлэв.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний хүрээнд хамаарах 7 /долоо/ зорилтын хүрээнд 31 арга хэмжээг тусгасан.

2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах үндсэн арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн биелэлтийн тайланг үндэслэн Хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд ерөнхий гүйцэтгэл 76.77 хувьтай үнэлэгдлээ. Арга хэмжээний гүйцэтгэлийг хувиар задлан үзүүлбэл:

30% -тай 5 арга хэмжээ

40 %-тай 1 арга хэмжээ

50% -тай 3 арга хэмжээ

70%-тай 3 арга хэмжээ

90%-тай 7 арга хэмжээ

100% -тай 12 арга хэмжээ байна.

Нийтдээ 19 арга хэмжээний биелэлт хангалттай сайн буюу 2024 оны эцэст тавьсан зорилттоо хүрэхээр байна. Харин үлдэх арга 12 арга хэмжээний хувьд

хөтөлбөрийн эцсийн байдлаар дүн шинжилгээ хийх үед биелэлтийг ахиулах шаардлагатай гэж үзлээ.

Иймээс тайланд ахиц гаргах шаардлагатай хяналт-шинжилгээ, үнэлгээний эхний хагас жилийн байдлаар гаргасан дүгнэлт, зөвлөмжийг дор бэлтгэлээ.

Мөн үүнээс гадна Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлт болон санхүүжилтийн тайланг хавсралт 2, 3-аар бэлтгэсэн ба шалгуур үзүүлэлтийн тайлангийн хувьд төсвөөс шалтгаалах 1 арга хэмжээнээс бусад арга хэмжээ 100 хувийн биелэлттэй байгааг онцолж байна.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Дээрх 31 арга хэмжээнээс 2023 оны төсөвт суутгуулахаар төсвийн санал хүргүүлсэн боловч, батлагдаагүй болон ахиц гараагүй, тасалдсан, эрчимжүүлэх шаардлагатай хэд хэдэн арга хэмжээ байгааг үүгээр онцолж байна. Үүнд:

- “4.1.3. Цахим засаглалын тогтолцоог боловсронгуй болгож, технологийн дэд бүтэц, төрийн цахим үйлчилгээг нэгдсэн бодлого, төлөвлөлттэй хөгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх” ажлын явцыг эрчимжүүлэх шаардлагатай буюу 50 хувиар үнэлгээ хийгдсэн байна. Уг ажлын хувьд Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсвийг 2023 оны төсөвт тусгуулахаар Сангийн яам болон Монгол Улсын Их хуралд 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 албан бичгээр хүргүүлсэн боловч, Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй. Иймээс Монгол Улсын суурь гэрчилгээжүүлэх байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх системийг шинэчлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцооллыг гаргаж, Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад “Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх” төслийн хэрэгжүүлэхээр тогтсон. Уг төслийн хүрээнд “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх” төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл хэрэгжүүлэх нэгжид 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдөр хүргүүлсэн. Ажлын даалгаварт тоон гарын үсгийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх, цагийн бүртгэлийн системийг шинээр байгуулахад шаардлагатай программ хангамж, тоног төхөөрөмж, хийгдэх ажлын жагсаалтыг тусгасан” гэж тайлагнасан бөгөөд одоогоор үндсэн зорилтыг биелүүлэх ажил эхлээгүй гэж харагдахаар байна.

Өөрөөр хэлбэл Улсын төсөвт тусгагдаагүй боловч, Ухаалаг Засаг-2 төслийн хүрээнд хийж гүйцэтгэхээр Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төслийн ажлын даалгаварт Дэлхийн Банкнаас ирүүлсэн саналыг тусган, Ухаалаг Засаг-2 төсөл хэрэгжүүлэх нэгжтэй хамтран тендерийн баримт бичгийг боловсруулж, тоног төхөөрөмжийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил хийгдэж байна. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар “Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийн суурь системийг шинэчлэх” төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Үнэлгээний хорооны хуралдаанаар тендерийн баримт бичгийг боловсруулж, олон улсын тендер зарлах зөвшөөрөл авахаар Дэлхийн Банканд хүргүүлсэн зэргээс үзвэл цаашид хэрэгжих боломжтой байна.

- Дээрх зорилтын хүрээнд төлөвлөсөн “Үндэсний тоон гарын үсгийн хэрэглээнд хөндлөнгийн аудитын байгууллагаар дүгнэлт хийлгэж олон улсын жагсаалтад оруулах” ажлын хувьд мөн адил он оны төсөвт удаа дараа тусгуулахаар санал илгээсэн ч төсөв тавигдаагүй шалтгаанаар суурь ажлууд хийгдэж байгаа буюу “

Дэлхийн Банкны Олон Улсын Хөгжлийн Ассоциатай байгуулсан Ухаалаг засаг-2 төслийн хүрээнд “Үндэсний нийтийн түлхүүрийн хэрэглээнд хөндлөнгийн байгууллагаар аудит хийлгэх” төслийн ажлын даалгаврыг боловсруулан төсөл

хэрэгжүүлэх нэгжид хүргүүлсэн. Ажлын даалгаварт шинээр байгуулагдах суурь систем, цагийн бүртгэлийн системд аудит хийх байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, тавигдах шаардлагыг тусгасан. Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх төслийн ажлын даалгаварт Дэлхийн Банкнаас ирүүлсэн саналыг тухай бүр тусгасан. Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн А/71 дүгээр тушаалаар "Үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцэд хөндлөнгийн аудит хийх" төслийн ажил гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог байгуулсан. Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх төсөл бүрэн хэрэгжиж дууссаны дараа олон улсын байгууллагаар аудит хийлгэх ажлыг гүйцэтгэнэ." гэж тайлагнасан байна.

- Мөн хөтөлбөрийн "4.1.5. Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ, шаардлагыг хангах дэд бүтцийг байгуулж, хамрах хүрээг өргөжүүлж, багтаамжийг нэмэгдүүлнэ." гэсэн зорилтын хүрээнд "Үндэсний хиймэл дагуул хөөргөх хууль эрхзүйн орчныг бүрдүүлэх" арга хэмжээний хувьд одоогоор "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэлийн төслийг боловсруулж, 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/93 дугаар тушаалаар "Монгол Улсад сансар судлалыг хөгжүүлэхэд баримтлах чиглэл"-ийг баталсан. Сансрын тухай хууль, тогтоомжийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох 34 асуумжийг боловсруулж, 37 байгууллагад хүргүүлэн санал авч судалгааг хийсэн. Мөн 23 орны сансар судлалтай холбоотой хууль, бодлогын баримт бичгийг судалсан" гэж тайлагнаснаас үзвэл одоогоор хууль, эрх зүйн орчин бүрдээгүй, судалгаа хийх, санал асуумж авах шатанд хэрэгжиж байна гэж үзэж 30 хувиар үнэлгээ хийгдлээ.

- Хөтөлбөрийн "4.1.7. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ" гэсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн "Мэдээлэл, холбооны өндөр технологи-инновацийн кластер байгуулах", "МХХТ-ийн хэрэглээний өрх болон хувь хүний судалгааг хийх" ажлын явц удаашралтай, ахицгүй, 2024 оны зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй гэж үзэж үнэлгээ хийлээ.

- Хөтөлбөрийн "4.1.9. Мэдээллийн технологийн энтрепренёр, гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, үндэсний тоон контентыг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэд оруулна" гэсэн зорилтын хүрээнд "Төвийн бүсэд тоон контент үйлдвэрлэлийн инкубатор төв байгуулах" ажлын явц удаашралтай, төсөв шийдвэрлэгдээгүйн улмаас "Мэдээлэл технологийн үндэсний парк ААТҮҮГ-ыг түшиглэн Мэдээлэл, хандалтын төвийг байгуулахаар шийдвэрлэж, Бүгд Найрамдах Солонгос Улсын талаас засвар үйлчилгээний ажил, холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэн "Мэдээлэл хандалтын төв"-ийг байгуулж, 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нээлтээ хийсэн. Уг төвд цахим ур чадвар чадамжийг дээшлүүлэх сургалтын 2 танхим, контент хөгжүүлэлтийн 2 танхим, конференцын 1 танхим, интернэт үйлчилгээний 1 танхим, нийт 6 танхимыг хүлээн авах хэсгийн хамт тохижуулж, тоноглогсон. Энэхүү төвийн контент хөгжүүлэлтийн танхимд үндэсний контент хөгжүүлэгчдэд зориулсан сургалт зохион байгуулах, бүтээсэн контентыг олон нийтэд сурталчлах зэрэг үйл ажиллагааг явуулахаас гадна олон нийт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд сургалт хийх зориулалттай. Бүсчилсэн контент үйлдвэрлэлийн төв байгуулах төсөв тусгагдаагүй тул төвийг байгуулах боломжгүй байна" гэж тайлагнасан нь уг ажил цаашид хийгдэх боломжгүй болсныг илтгэж байна.

Дээрхээс гадна Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгуулсан нийт 7 зорилтын хүрээнд 31 арга хэмжээг 2020-2024 оны хооронд хийхээр төлөвлөсөн боловч, зарим арга хэмжээний зорилтот түвшинг он оноор нь нарийвчлан тусгаж өгөөгүйгээс тухайн жилд ямар ажил хийж гүйцэтгэсэн байхаар тогтоосон нь төдийлөн тодорхойгүй, хөтөлбөр хэрэгжиж дуусахад зарим арга хэмжээний биелэлт хангагдахгүй байх магадлалтай байгаа зэрэг нь хэд хэдэн шалтгаантай байна.

Тухайлбал зорилтын хүрээнд төлөвлөсөн арга хэмжээнүүд тооцоо судалгаагүй, төсөвт тухай бүр санал хүргүүлдэг боловч батлагддаггүй, хүрэх зорилго, үр дүнг нарийвчлан тооцоогүй зэргээс шалтгаалж байна.

Тав. Цаашид анхаарах зөвлөмж

Иймд цаашид бодлогын баримт бичигт арга хэмжээг төлөвлөн оруулахдаа зорилт, хүрэх түвшнийг ойлгомжтой хэмжигдэхүйц /шалгуур үзүүлэлт тус бүрийг тавьсан зорилгод нийцүүлэх/ байхаар тусгаж хэвшихийг газар хэлтсийн дарга нар анхаарах шаардлагатайг цохон газар хэлтэс тус бүрд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

Бодлого, төлөвлөлтийн газар, Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Харилцаа холбооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад:

1. Дотоод нэгждээ бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, стратеги төлөвлөгөөний хэрэгжилт гэх мэт хэрэгжилтийн тайлан гаргаж байх албан хаагчдыг тодорхой болгож, хариуцах эзэнтэй байхаар зохион байгуулах;

2. Төсвөөс шалтгаалах ажлын төлөвлөгөөг гаргахдаа бодит, дүн шинжилгээтэй, баримтад тулгуурласан хэрэгжихүйц байдлаар төлөвлөж байх;

3. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төлөвлөгөөний хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;

4. Нэгжийн албан хаагчид үр дүнд суурилсан бодит нотолгоонд тулгуурласан тайлан бичиж ирүүлэх;

5. Төрийн захиргааны тайлан мэдээ нэгтгэж буй албан хаагчид тайлан мэдээг заасан хугацаанд шуурхай өгч хэвших;

6. Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

7. Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний эцсийн тайлан 2024 оны эцсээр тайлагнагдах тул эрчимжүүлэх шаардлагатай болон 2024 онд хүрэх түвшинд нийцүүлэх, биелэлтийг хангах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллах;

8. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн зөвлөмжийг мөрдлөг болгон эрчимжүүлэх шаардлагатай ажлуудад анхаарлаа хандуулж, төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн биелэлтийг ахиулахад шат дараалалтай арга хэмжээ авч ажиллаж хэвших;

Төрийн захиргааны удирдлагын газарт:

1. Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;

2. Бодлогын баримт бичгийн тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан бичсэн тайлан өгч хэвших;

3. Харьяа салбарын байгууллагаас сайдын 2024 оны А/38 дугаар тушаалын дагуу тайланг авч хэвших;

4. Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-oOo-



ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 06 сарын 27 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийн тухай

“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах 2024 оны 2 дугаар улирлын хэрэгжилтийн талаар:

Хурлыг 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 10 цагаас тус яамны “Хурлын танхим”-д эхлүүлж, Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг удирдан явуулав.

Хуралд:

1. Б.Билэгдэмбэрэл /Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
2. Э.Насанбат /Кибер аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/
3. Х.Сүрэнхорол /Бодлого төлөвлөлтийн газрын дарга/
4. Ц.Борхүү /Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга/
5. Л.Нямдорж /Хуулийн хэлтсийн дарга/
6. Б.Золбоо /Цахим засаглалын хэлтэс/
7. Д. Батбаяр /Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга/
8. П.Дэлгэрмаа /Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/ нар оролцов.

Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч А.Түвшинзаяа оролцов.

Хэлэлцсэн асуудал:

Тус яамны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 31 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах тухай.

СОНССОН нь:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгасан 31 арга хэмжээний хэрэгжилтэд 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн шинжээч А.Түвшинзаяа

танилцуулав. /Биелэлт, биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тэмдэглэлийг хавсаргав/


ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2024 оны 2 дугаар улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Борхүү/-т даалгаж шийдвэрлэв.

2.“Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг ахиулж ажиллах үүргийг яамны нэгжийн дарга нарт, хөтөлбөрийн биелэлтийг тухай бүр заасан хугацаанд тайлагнахыг Төрийн захиргааны удирдлагын газрын Яамны төлөвлөгөө, тайлан, өргөдөл гомдол хариуцсан ахлах мэргэжилтэн /Д.Мөнхсарнай/-д үүрэг болгов.

Хурал 10 цаг 50 минутад дуусав.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Б.БАТЦЭЦЭГ